

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРЛИЙГ БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРӨЛТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

TYPES OF PUNISHMENT IN CRIMINAL LAW OF MONGOLIA TYPES OF PENALTIES UNDER PRC CRIMINAL LAW COMPARATIVE STUDIES



С.Ууганбаатар

Дотоод хэргийн их сургуулийн

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, ахмад*

Товч утга: Монгол улсын хувьд газар зүй геополитекийн мөнхийн хөрш болсон ОХУ, БНХАУ-ын улс төр, нийгэм эдийн засгийн байдал, соёл уламжлал, зан заншил, эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомж зэргийг зайлшгүй судлах шаардлагатай билээ. Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй дараах эх сурвалжийн хүрээнд харьцуулсан судаллаа.

Түлхүүр үгс: Монгол улс, эрүүгийн хууль, ялын төрөл, ялын бодлого, эрүүгийн хариуцлага, эрх зүй, хэм хэмжээ.

Abstract: For Mongolia, it is necessary to study the political, socio-economic situation, culture, traditions, customs, legal system and laws of Russia and China, which are the eternal neighbors of geography and geopolitics. The types of punishments under the Criminal Law of Mongolia have been compared with the types of punishments under the Criminal Law of the People's Republic of China in the context of the following sources.

Keywords: Mongolia, criminal law, type of punishment, punishment policy, criminal responsibility, law, norms.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын их хурлаас Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дүгээр сарын 03-ны өдөр шинэчлэн баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

БНХАУ-ын эрүүгийн хуулийг БНХАУ-ын 8-р хуралдааны тус улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын 5-р хуралдаанаас 1997 оны 3 дугаар сарын 14-ний өдөр

засвар оруулж тогтоожээ.¹⁴⁰ Уг хуулийг 1997 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

Монгол улсын болон БНХАУ-ын Эрүүгийн хуульд заасан ялын төрлүүдийг харьцуулалтын аргаар зэрэгцүүлэн жишиж тодорхойлох замаар харьцуулан судаллаа.

Харьцуулсан эрүүгийн эрх зүйн шижлэх ухааны дээрх аргыг, хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Баярсайхан өөрийн бүтээлдээ “Дэлхийн улс орнуудын эрүүгийн хууль тогтоомж, тэдгээр актуудыг бүхэлд нь буюу институт бүлэг, хэсгээр нь нормативийн аргаар харьцуулах, улмаар гэмт хэрэг, ялын талаар эрх зүйн хэм хэмжээний хэлбэр, бүтэц, агуулга тогтолцоог зэрэгцүүлэн жишиж тодорхойлох зэргээр институцын түвшинд харьцуулж авч үзэх нь арга зүйн хувьд чухал нөлөө үзүүлнэ.¹⁴¹ “ гэж тодорхойлсон байдаг.

Монгол улсын Эрүүгийн хуулийн тавдугаар бүлэгт эрүүгийн хариуцлагын зорилго, ялын төрлийг тодорхойлж, ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр ангилжээ.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн гуравдугаар бүлэгт эрүүгийн шийтгэлийн төрлийг тодорхойлж гол эрүү ба нэмэлт эрүү гэж хуваасан байна.

Монгол улсын эрүүгийн хуульд үндсэн ял 4, нэмэгдэл ял 1 байхаар хуульчилсан.

Харин БНХАУ-ын эрүүгийн хуульд гол эрүүгийн төрөл /үндсэн ял/ 5, нэмэлт эрүүгийн төрөл /нэмэгдэл ял/ 3 байхаар хуульчилсан бөгөөд нэмэлт эрүүгийн төрлийг дангаар нь тохируулан хэрэглэж болохоор хуульчилжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
Тавдугаар бүлэг Эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл	Гуравдугаар бүлэг Эрүү шийтгэл Нэгдүгээр хэсэг Эрүүгийн шийтгэлийн төрөл
5.1 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлагын зорилго Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт	32-р зүйл. Эрүүгийн шийтгэлийг гол эрүү ба нэмэлт эрүү гэж хуваана

¹⁴⁰ Г.Батзориг, Э.Зуунасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль орчуулга УБ хот. 2006 он.

¹⁴¹ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ хот. 2012 он. 22 дахь тал

хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.	
5.2 дугаар зүйл. Ялын төрөл Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна: 1.торгох ял; 2.нийтэд тустай ажил хийлгэх ял; 3.зорчих эрхийг хязгаарлах ял; 4.хорих ял; 5.эрх хасах ял.	33-р зүйл. Гол эрүүгийн төрөл зүйл нь доорхи мэт байна. (Нэг) Захиран хамаарах; (Хоёр) Хорьж хөдөлмөрлүүлэх; (Гурав) Хугацаатай хорих; (Дөрөв) Хугацаагүй хорих; (Тав) Алахаар шийтгэх;
-Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, -Эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ.	34-р зүйл. Нэмэлт эрүүгийн төрөл зүйл нь доорх мэт байна. (Нэг) Зоосоор ялгах; (Хоёр) Улс төрийн эрхийг хасах; (Гурав) Эд хөрөнгийг хурааж авах; Нэмэлт эрүүг дангаар нь тохируулан хэрэглэж ч болно.

Торгох ял

Монгол улсын хувьд үндсэн ял бөгөөд Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн хүнд дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөр оногдуулж, торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар сольж болохоор хуульчилсан. Эрүүгийн хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байх бөгөөд Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болдог.

БНХАУ-ын хувьд нэмэлт ялд тооцдог. Эрүүгийн хуульд торгуулийн хэмжээг хэд байхыг томъёолоогүй байна. Харин хориглогдошгүй гай гамшиг учирвал, нөхцөл байдлыг тодруулж торгуулийн хэмжээг багасгах эсвэл бүрэн хэлтрүүлж болохоор хуульчилсан нь дэвшилттэй зүйл байна гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
------------------------------------	--------------------------------

5.3 дугаар зүйл. Торгох ял 1.Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгж /цаашид "нэгж" гэх/-тэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэнэ. 2.Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна. 3.Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. 4.Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно. 5.Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино. 6.Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг торгох ялаар солихгүй.	Зургаадугаар хэсэг Зоосоор яллах 52-р зүйл. Зоосоор яллахаар шийтгэхдээ хийсэн ялынх нь үйл байдлыг үзэж яллах зоосны тоог тогтоох ёстой. 53-р зүйл. Ялласан зоосыг шүүн таслалт тогтоосон хугацааны дотор нэг удаад буюу хугацаа хувааж тушаана. Хугацаа дүүргэлт тушаахгүй байвал албадан тушаалгана. Ялласан зоосыг бүгдийг тушааж дийлэхгүй байвал Ардын шүүх хороо гүйцэтгэгч хүнд гүйцэтгэж болох эд хөрөнгийг нь олж мэдмэгц цаг тухайд нь нэхэмжилж тушаалгах ёстой. Хориглогдошгүй гай гамшиг тушаахад үнэхээр учиртай болон байвал байдлыг нь үзэж багасгах буюу хэтрүүлж болно.
--	--

Нийтэд тустай ажил хийлгэх ял

Дээрх ял шийтгэл БНХАУ-ын эрүүгийн хуулийн ял шийтгэлийн төрөлд байдаггүй бөгөөд Монгол улсын ялын төрөлд дараах байдлаар тодорхойлжээ. Уг ялыг үндсэн ялын чанартай хэрэглэх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.

Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтан уг ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар тооцож сольж болохоор зохицуулсан бөгөөд

хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй байхаар хуульд заасан байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

5.4 дүгээр зүйл.

Нийтэд тустай ажил хийлгэх ял

- 1.Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ.
- 2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.
- 4.Ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.
- 5.Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.

Зорчих эрхийг хязгаарлах ял

Дэлхийн улс орнуудын хууль, эрх зүйн хөгжил нь нийгмийн хөгжлийнхөө үйл явцтай зэрэгцэн шинэчлэгдэж боловсронгуй болсоор байгаагийн тод жишээ нь технологийн дэвшлийг ашиглан цахим төхөөрөмжийг гэм буруутай хүний биед зүүж байршлыг тогтоон, зорчих маршрутыг хязгаарлан, хяналт тавьдаг болсон ядвал юм.

Манай улсын хууль тогтоомж, бодлого боловсруулагчид энэхүү ялыг улсынхаа хөрсөнд буулгах гэж 2015 онд Эрүүгийн хуульд ялын бодлогыг тусгаж, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хэрэгжих арга замыг батлуулж, хэрэгжилтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр тус тус заасан.

Монгол улсад шүүхээс ял шийтгэгдсэн этгээдийн зорчих хөдөлгөөнд хяналт тавих зарчмаар ашигладаг цахим тоног төхөөрөмжийг ял эдлүүлэх ажиллагаанд 2021 оноос хэрэглэж эхэлсэн бөгөөд, боловсронгуй болгох үйл явц явагдсаар байна.

Шүүхээс оногдуулсан хязгаарлалтын дагуу хориглосон болон зөвшөөрсөн бүс, замын чиглэлийг тогтоон өгч, тухайн ялтанд аюулгүй ажиллагааны болон ашиглалтын талаар тайлбар, танилцуулга, зааварчилгааг өгдөг бөгөөд хэрэв заасан

хориглолт, хязгаарлалтыг зорчих, цахим бугуйвчийг таслах, гэмтээх зэрэг зөрчлийг гаргавал сануулга өгөх, гаргасан зөрчлөө дахин давтан гаргах, хориглолт хязгаарлалтыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар солихоор хуульчилж өгсөн.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь хүний зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн байдал, нийгэмд учруулсан хор уршгийг харгалзан нийгэм, хамт олныхоо дунд ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, гэр бүл үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн ял шийтгэлийн нэг хэлбэр бөгөөд ялтан этгээдийг нийгэм, хамт олон, гэр бүлээс нь тусгаарлахгүйгээр ажиллаж, сурч байх явцдаа хүмүүжих, засрал төлөвшлийг олох боломжийг бий болгодог.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэл нь хүмүүнлэг ёсны үзэл санаа давамгайлснаараа уг ялаар шийтгэгдсэн ялтандаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй байдлаараа улс эх орондоо давуу талыг олгодог бөгөөд орчин үеийн техник технологийн дэвшлийг ашиглан ялтан этгээдийн чөлөөтэй зорчих эрхэнд хязгаарлалт тогтоон, ялын мөн чанар, ялын зорилгыг хэрэгжүүлдгээрээ хүмүүнлэг энэрэнгүй нийгмийн сонгодог хэлбэрийг бүрдүүлдэг байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

5.5 дугаар зүйл.

Зорчих эрхийг хязгаарлах ял

1.Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.

2.Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно.

3.Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

4.Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Хорих ял

Монгол улсад хорих ялын үндсэн хугацаа адил 6 сараас 20 жил хүртэл байх бөгөөд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд бүх насаар хорих хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан бол БНХАУ-д зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг хугацаагүй хорихоор шийтгэдэг байна.

Хуульд хорих дэглэмийг зааж өгсөн нь 2 улсын эрүүгийн хуульд адил мэт боловч Монгол улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ял эдлэх дэглэмийг хуульчилж өгснөөрөө онцлог байна.

БНХАУ-ын хувьд хорих ял шийтгүүлсэн этгээд хөдөлмөрлөх чадалтай бол заавал хөдөлмөрт оролцож хүмүүжигдэн өөрчлөгдөх талаар хуульчилжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
5.6 дүгээр зүйл. Хорих ял 1.Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ. 2.Нээлттэй, хаалттай хорих байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно. 3.Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ. 4.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно. 5.Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ.	Хугацаатай хорих, хугацаагүй хорих 45-р зүйл. Хугацаатай хорих хугацааг тус хуулийн 50-р зүйл, 69-р зүйлд тогтоосныг гаргавал 6 сараас дээш арван таван жилээс доош байлгана. 46-р зүйл. Хугацаатай хорих, хугацаагүй хорихоор шийтгэгдсэн ялт этгээдийг гянданд буюу бусад гүйцэтгэх талбарт гүйцэтгэнэ. Хөдөлмөрөх чадалтай нь цөм хөдөлмөрт оролцож, хүмүүжигдэн өөрчлөгдөх ёстой. 47-р зүйл. Хугацаатай хорих эрүүгийн хугацааг шүүн таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс тооцно. Шүүн таслалтыг гүйцэтгэхээс өмнө урьдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацааны нэг өдрөөр тооцно.

6.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорин таван жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ. 7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар ялтныг суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ. 8.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулахгүй. 9.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн бол ял шийтгүүлсэн гэмт хэрэгт нь хорих ял оногдуулахаар заасан эсэхээс үл хамааран эдлээгүй үлдсэн ялыг энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу сольж хорих ял оногдуулна.	
--	--

Эрх хасах ял

Монгол улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг, нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр, ялын хугацаа болон ялыг хэрхэн тоолох зэргийг нарийвчлан зохицуулсан байхад БНХАУ-д нэмэгдэл ялын чанартай хэрэглэж Улс төрийн эрхийг нь хасаж шийтгэдэг байна.

Улс төрийн эрхэд сонгох сонгогдох эрх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн нэгдэх, жагсаал цуглаан явуулах, Төрийн байгууллагад албан тушаал хаших, Улсын өмчлөлийн компанид аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын байгууллагад удирдах албан тушаал хаших зэргийг хамааруулдаг байна.

Монгол улсад эрх хасах ялыг нийтийн албан тушаалтан болон тодорхой эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй этгээдэд оногдуулдаг бол БНХАУ-д улсын болон хувийн хэвшлийн удирдах ажилтан болон жирийн иргэнд ч оногдуулж болох байдлаар зохицуулжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
5.7 дугаар зүйл. Эрх хасах ял 1.Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хориглохыг эрх хасах ял гэнэ. 2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулна. 3.Шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолно. 4.Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг хүүхдийн эсрэг, эсхүл 16 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг үйлдсэн эцэг, эх, асран хамгаалагч,	Долдугаар хэсэг Улс төрийн эрхийг нь хасах 54-р зүйл. Улс төрийн эрхийг нь хасах гэж доорх эрхүүдийг хасах болно. 1, Сонгох эрх ба сонгогдох эрх; 2, Үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөт эрх; 3, Төрийн байгууллагад тушаал үүрэх эрх; 4, Улсын өмчлөлийн компанид аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын бүлгийг жолоодох тушаал үүрэглэх эрх; 55-р зүйл. Улс төрийн эрхийг нь хасах хугацааг нь тус хуулийн 57-р зүйлд тогтоосныг гаргавал нэг жилээс дээш, таван жилээс доош байлгана. Захиран хамаарахаар шийтгээд улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэсэн байвал улс төрийн эрхийг хасах хугацаагаар захиран хамаарахын хугацаатай адил байлгах зэргээр гүйцэтгэнэ. 56-р зүйл. Улсын амар төвшинд хор хөнөөл учруулсан ялт этгээдэд улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэх ёстой. Зориуд хүн алсан, хүчиндсэн, гал тавьсан, хор хаясан, тонон дээрэмдсэн зэрэг нийгмийн эмх дэглэмийг хүнд ноцтой эвдсэн ялт этгээдийн улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэж болно. Улс төрийн эрхийг нь хасахаар дангаар тохируулан хэрэглэвэл хуулийн

харгалзан дэмжигчид оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно.	хуваарь дүрмийн тогтоолыг үндэслэнэ. 57-р зүйл. Алах эрүү ба хугацаагүй хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн улс төрийн эрхийг нь нэг насаар нь хасах ёстой. Алах эрүүг нь алгуурлан гүйцэтгэх эрхийг нь хугацаатай хорих болгон хөнгөрүүлэх үед улс төрийн эрхийг нь хасах нэмэлт эрүүг нь гурван жилээс дээш арван жилээс доош болгож бууруулах ёстой. 58-р зүйл. Улс төрийн эрхийг нь хасах нэмэлт эрүүгийн хугацааг хорих эрүү, хорьж хөдөлмөрлүүлэх эрүү дуудсан өдөр буюу тэнсэн сулласан өдрөөс эхлэн бодно. Улс төрийн эрхийг хасах эрүү нь гол эрүүгийн гүйцэтгэлийн хугацаанд хүчинтэй. Улс төрийн эрх нь хасагдсан ялт этгээд гүйцэтгэлийн хугацаанд хууль цааз, засаг захиргааны хууль тогтоол болон төрийн албаны хорооны дотоодыг хамгаалах салаа мөчрийн хамаа бүхий хянан хамааралтын тухай тогтоолыг журамлан сахиж хяналтыг дагах ёстой. Тус хуулийн 54-р зүйлд тогтоосон эрхүүдийг хэрэглэж болохгүй.
---	---

ХОРЬЖ ХӨДӨЛМӨРЛҮҮЛЭХ ЯЛ

Дээрх ял нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих бөгөөд ял шийтгэгдсэн этгээдийг хорьж хөдөлмөрлүүлж, мөн ажлын хөлсийг тооцож олгодог байхаар зохицуулжээ. БНХАУ-ын хувьд дээрх ялыг үндсэн ялын чанартайгаар хэрэглэж байна.

БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
Гуравдугаар хэсэг Хорьж хөдөлмөрлүүлэх

42-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэх хугацааг нэг сараас дээш зургаан сараас доош байлгана.

43-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэх шийтгэгдсэн ялт этгээдийг дотоодын хамгаалах байгуулагад ойрхон газарт нь гүйцэтгэнэ.

Гүйцэтгэлийн хугацаанд хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэгдсэн ялт этгээд сард нэгээс хоёр өдрийн чөлөөгөөр гэртээ харьж болно. Хөдөлмөрт оролцвол зохих хэмжээний хөлс хүч олгож болно.

44-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэхийн эрүүгийн хугацааг нь шүүх таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс бодно. Шүүн таслалтыг гүйцэтгэхээр өмнө урьдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацаанд нэг өдрөөр тооцно.

Цаазаар авах ял

Монгол улсын хувьд Монгол улсыг цаазын ялгүй орон хэмээн даян дэлхийд зарлаж, цаазаар авах ялыг 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд тусгаагүй явдал нь хүний эрхийг хангах баталгаа болсон билээ.

Харин БНХАУ-д ял үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй болон шүүн таслах үед жирэмсэн байгаа эмэгтэйд алах ялыг хэрэглэхгүй бөгөөд бусад этгээдэд хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн бол алах ялыг хэрэглэхээр зохицуулжээ.

БНХАУ-ын хувьд Ардын шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой бөгөөд алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан зөвшөөрч болно. Алгуурлан гүйцэтгэх хугацаа 2 жил байхаар зохицуулсан бөгөөд энэ хугацаанд зориуд ял хийгээгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгож хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавьяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш, хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлдэг байна.

БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Тавдугаар хэсэг

Алахаар шийтгэх

48-р зүйл. Эрүүг гагцхүү туйлын хүнд ял хийсэн ялт этгээдэд л тохируулан хэрэглэнэ. Алахаар шийтгэх ёстой ялт этгээдийг заавал доор нь гүйцэтгэх хэрэгтэй биш байвал алахаар шийтгэхийг хоёр жил алгуурлан гүйцэтгэж болно.

Хууль ёсоор Ардын шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой. Алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан зөвшөөрч болно.

49-р зүйл. Ял хийх үедээ бүх л арван найман насанд үл хүрсэн ба шүүх таслах үед жирэмсэн байх эмэгтэйд алах ялыг тохируулан хэрэглэхгүй.

50-р зүйл. Алахаар шийтгэхээр алгуурлан гүйцэтгэгсэд алахыг алгуурлан гүйцэтгэх хугацаа нь хэрвээ зориуд ял хийсэнгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгож хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавьяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш, хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлнэ. Хэрвээ зориуд ял хийсэн бөгөөд байцаан тодлоод үнэн магад байвал. Ардын дээд шүүх хороогоор хянан зөвшөөрүүлээд алах эрүүг гүйцэтгэнэ.

51-р зүйл. Алахаар шийтгээд алгуурлан гүйцэтгэх хугацааг нь шүүх таслалтыг нь тогтоосон өдрөөс эхлэн бодно. Алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэхийг хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацааг түүний алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэх хугацаа дууссан өдрөөс эхэлж болно.

Захиран хамаарах ял

БНХАУ-н эрүүгийн хуулийн 38-р зүйлд Захиран хамаарах хугацааг гурван сараас дээш, хоёр жилээс доош байлгана. Захиран хамаарагдахаар ял этгээдийг Дотоод хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ.

Доктор Д.Баярсайхан дээрх ялыг Хяналт тогтоох ял¹⁴² гэж тодорхойлоод 2 сараас 3 жил хүртэл хугацаатай байх бөгөөд дотоодыг хамгаалах байгууллагын шууд хяналтад ялыг хэрэгжүүлдэг байна. Монгол улсын хувьд дээрх ялын төрөл хуульчлагдаагүй байна.

БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Захиран хамаарах

38-р зүйл. Захиран хамаарах хугацааг гурван сараас дээш, хоёр жилээс доош байлгана. Захиран хамаарагдахаар ял этгээдийг Дотоод хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ.

39-р зүйл. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээд гүйцэтгэлийн хугацаандаа доорх тогтоолуудыг журамлан сахих ёстой.

(Нэг) Хууль цааз, засаг захиргааны хууль, тогтоолыг журамлан сахиж,

(Хоёр) Гүйцэтгэх байгууллагын зөвшөөрөлгүйгээр үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэрэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөт эхийг хэрэглэж болохгүй

¹⁴² Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ хот. 2006 он. 259 дэх тал

(Гурав) Гүйцэтгэх байгууллагын тогтоолоор өөрийн ажиллагааны байдлаа мэдүүлэх үүрэгтэй

(Дөрөв) Зочинтой уулзах тухай Гүйцэтгэх байгууллагын тухай журмыг журамлан сахих хэрэгтэй.

(Тав) Сууж байгаа хот, суурьнаас салах буюу нүүж явбал гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж зөвшөөрүүлэх ёстой.

Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээдэд хөдөлмөрийн дунд адил хөдөлмөрт адил хөлс авах ёстой.

40-р зүйл. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээдийн захиралтын хугацааг нь дүүрвэл гүйцэтгэх байгууллага нь тус хүн ба түүний байгаа нэгжид нь буюу сууж байгаа газрынх нь олон түмэнд захирагдлаас чөлөөлснийг нь захирвал зохино.

41-р зүйл. Захиран хамаарах эрүүгийн хугацааг нь шүүн таслалтыг гүйцэтгэсэн өдрөөс эхэлж бодно. Шүүн таслалтыг нь гүйцэтгэхээс өмнө урдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацааны хоёр өдрөөр нугалан бодно.

Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй харьцуулан судлахад 2 улсын ял шийтгэлийн төрөл ерөнхийдөө адил төстэй бөгөөд тухайн орны нийгэм эдийн засгийн байдал, соёл, өв уламжлал, ёс заншил, төрийн тогтолцоо, эрх зүйн бүлээсээ хамаарч тус тусын онцлогтой байна.

Монгол улсын хувьд дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн чиг хандлагатай хөл нийлүүлэн эрүүгийн ялын бодлогодоо хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оруулж өгсөн нь судалгаанаас харагдаж байна.

Тухайлбал шинэчлэн баталсан эрүүгийн хуульд 215 төрлийн үйлдэл /эс үйлдэхүй/-ийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байдаг бөгөөд тэдгээрийн 127 гэмт хэрэгт шинэ тутам хэрэгжиж байгаа зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулахаар хуульчилжээ.

Судалгааны явцад БНХАУ-ын хорих ялын бодлого нь хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг заавал ажил хөдөлмөр эрхлүүлэхэд оршдог бөгөөд энэ нь уг хуулийн хөдөлмөрлөх чадалтай л бол заавал хөдөлмөр эрхлүүлнэ гэж томъёолсноос тодхон харагдана.

Мөн торгох ялыг хэмжээг хуульд тодорхой зааж өгөөгүй байгаа нь тухайн гэмт этгээдийн хөрөнгө чинээ, орлого зэргийг харгалзан шүүхээс тогтоож болохоор нээлттэй байгааг Монгол улсад тусган авч хэрэгжүүлэх зүйтэй байна. Хуулийн дээрх заалт өдгөө манай улсад шүдний өвчин мэт асуудал үүсгэж байгаа торгуулийн ялын биелэлтэд чухал ахиц гаргана гэж судлаачийн хувьд үзэж байна.

Гэмт этгээдийн эд хөрөнгийг хураахаас өмнө төлбөр авагч, хохирогчийн хохирол төлбөрийг эхлэн барагдуулж байгаа нь сайшаалтай байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Хууль тогтоомж:

1. Эрүүгийн хууль 2015 он

Ном гарын авлага:

1. Г.Батзориг, Э.Зуунасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль орчуулга УБ., 2006
2. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2006.
3. Д.Баярсайхан. Орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн хандлага. Шударга ёс сэтгүүл. УБ., 2010

Цахим эх сурвалж:

1. <https://www.criminology.mn>
2. <https://www.legalinfo.mn>

---o0o---

Хилмийн эрх зүй

ГЭР БҮЛ БА ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

/алслагдсан сумдын жишээ нь дээр/**Л.Лхагвасүрэн***Хилийн албаны сургуулийн**Ар тал, эдийн засгийн тэнхимийн дэд профессор,**Хил судлал, боловсрол судлалын магистр, хошууч*

Товч утга: Миний судалгааны ажилд Монгол Улсын сүүлийн 5 жилийн гэр бүл төлөвлөлтийн байдал түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний талаар судалж түүнд үнэлэлт дүгнэлт өглөө. Судалгаанаас харахад сүүлийн 5 жилийн хугацаанд өмнөх оны мөн үеэс гэр бүл салалт нь харьцангуй ихсэж, гэрлэлтийн тоо нь буурч хоорондын хамаарал нь урвуу хамааралтай байна. Энэ хамаарал нь хилийн анги салбарт тодорхой хэмжээгээр оршиж байгааг анхаарал татаж байна. Монгол Улсад өнөөдрийн байдлаар гэр бүлээс гадуурх амьдралыг хуульчилсан эрх зүйн акт байхгүй байна. Төрөөс залуу гэр бүлийг дэмжих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон бусад нөлөөлөх хүчин зүйлийн талаар товч өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Залуучууд, гэр бүл, шилжилт, хөдөлгөөн, хил хамгаалах байгууллага.

Abstract: In my research, the family of Mongolia over the past five years analyzed the planning situation that followed him and evaluated him. Studies have shown that over the past five years, divorce rates have increased relatively from the same period the previous year, and the correlation between the number of marriages decreases is treacherous. It's noteworthy that this dependency is somewhat present in the border class sector. In Mongolia today, there is no legal action against extramarital life. The Government will provide a brief overview of the measures being taken to support young families and other influencing factors.

Keywords: Youth, family, migration, movement and border protection organization..

Өнөөгийн Монгол Улсын нийгэмд төрөлт буурч, хүн амын хөгшрөлт, гэр бүл, хүн амын хомсдол, эдийн засгийн тогтворгүй байдал, бүс нутгийн хүмүүсийн